

МОНГОЛ УЛСЫН

ҮНДСЭН ХУУЛЬД

ОРУУЛАХ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТИЙН ТӨСӨЛ



ХАРИУЦЛАГАТАЙ



ТОГТВОРТОЙ



ТЭНЦВЭРТЭЙ





**§ Үндсэн Хуульд
оруулах нэмэлт,
өөрчлөлтийн төсөл**



МОНГОЛЫН АРД ТҮМЭН БИД:

- Улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататган бэхжүүлж,
- Хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, үндэснийхээ эв нэгдлийг эрхэмлэн дээдэлж,
- Төрт ёс, түүх, соёлынхоо уламжлалыг нандигнан өвлөж,
- Хүн төрөлхтөний соёл иргэншлийн ололтыг хүндэтгэн үзэж,
- Эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгоно.

ХАРИУЦЛАГАТАЙ... ТОГТВОРТОЙ... ТЭНЦВЭРТЭЙ ...

Аливаа улсын Үндсэн хууль нь тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, хүний эрх, эрх чөлөөг бататган бэхжүүлэх, төрийн байгууллын үндсийг тогтоосон

- эв нэгдлийн гэрээ,
- улс төр-эрх зүйн тулгуур баримт бичиг,
- гол хууль байдаг билээ. Энэ ч жишгийн дагуу Монгол Улс 1992

онд шинэ Үндсэн хуулиа батлан мөрдүүлээд 27 жил боллоо. Энэ хугацаанд нийгэм, эдийн засаг, улс төрийн амьдрал зарчмын шинэтгэлүүд хийгджээ. Удаа дараагийн судалгаа, зөвлөлдөх санал асуулгын зөвлөмж, олон нийтийн хэлэлцүүлгийн дүн, эрдэм шинжилгээний хурал, харьцуулсан судалгааны үр дүн, эрдэмтдийн саналаас үзэхэд Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах нийгмийн захиалга бий болоод байгаа нь харагдаж байна. Үе үеийн УИХ-ын бүрэлдэхүүнээс Үндсэн хуульдаа зохих нэмэлт, тодотгол хийх санал санаачлага гарч байлаа. Энэ удаагийн УИХ иргэд олон нийт, улс төрийн нам, иргэний нийгмийн байгууллага, эрдэмтэн судлаачдын саналыг хүлээн авч бүртгэн, ангилж нэгтгэн судалж Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг боловсрууллаа. Энэхүү төслөөр:

- ард түмний төлөөллийн үүргээ хариуцлагатай хэрэгжүүлдэг Улсын Их Хурал;
- тогтвортой, хариуцлагатай Засгийн газар;
- хараат бус, шударга шийдвэр гаргах чадвартай Шүүх;
- нутгийн удирдлагын тогтолцоог боловсронгуй болгож эрх

мэдлийн хяналт-тэнцвэрийг сайжруулан бүх шатанд сахилга хариуцлага, дэг журам, шударга ёсыг бэхжүүлэх, хяналт-тэнцвэр, тогтвортой байдлыг хангахад чиглэсэн өөрчлөлтүүдийг оруулсан.

Үндсэн хуулийн 20 зүйлд нэмэлт, өөрчлөлт оруулж байгаа нь нийт зүйлийн 28,5 хувийг эзэлж байна. Төслийг боловсруулахад эх хуулийнхаа үзэл баримтлал, үндсэн зарчмыг ягштал баримталсан болохоо онцолж байна.

**МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬД ОРУУЛАХ
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТИЙН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ
АЖЛЫН ХЭСЭГ**



БАЙГАЛИЙН БАЯЛГИЙГ ТЭГШ, ШУДАРГААР ХУВААРИЛАХ



§6.2

Төрөөс байгалийн баялгийг ашиглахдаа тэгш байдал, шударга ёс, үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, тогтвортой хөгжлийг хангах зарчмыг баримтална.

Төрөөс байгалийн баялгийг ашиглах зарчим:


Тэгш байдал



Шударга ёс




Үндэсний эдийн
засгийн аюулгүй
байдал



Тогтвортой хөгжлийг
хангах





**УЛСЫН ИХ ХУРЛЫН
ХАРИУЦЛАГА,
ҮЙЛ АЖИЛЛАГААГ
САЙЖРУУЛАХ**



1. УИХ-ЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ ҮРГЭЛЖЛЭХ ХУГАЦАА



\$27.2

2000

50-аас доошгүй
ажлын хоног

1992

75-аас доошгүй
ажлын хоног

Төслийн
заалт

75-аас доошгүй
ажлын хоног

2000 оны нэмэлт, өөрчлөлт



- УИХ байнгын тасралтгүй ажиллагаатай болох нөхцөл хангагдана.
- УИХ-ын гишүүний хариуцлага нэмэгдэнэ.
- Хууль тогтоомжийн чанар сайжирна.



2. ХУРАЛДААНЫ ИРЦ БОЛОН САНАЛ ХУРААЛТ



§27.6



УИХ-ын нийт гишүүний олонхи нь буюу 39-өөс доошгүй гишүүнээр ирц бүрдэнэ

Асуудлыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэнэ



Хуулийг 39-өөс доошгүй гишүүний саналаар батална

Үндсэн хуулийн заалт

1992 он
26-аас доошгүй гишүүн

2000 он
20-иос доошгүй гишүүн

Төслийн заалт
39-өөс доошгүй гишүүн

§27.7

УИХ ил санал хураалтаар шийдвэр гаргана

2000 оны нэмэлт, өөрчлөлт

Үндсэн хууль, бусад хуульд заасан бол

хуралдаанд оролцсон гишүүдийн олонхи дэмжсэн бол

Нууц санал хураалт



- Хуулийн чанар сайжирна.
- УИХ-ын гишүүний хариуцлага нэмэгдэнэ.
- Асуудлыг олонхиор шийдэх ардчиллын зарчим хангагдана.
- Хууль батлахад ард түмний төлөөллийг хангана.



3. УИХ-ЫН ГИШҮҮН ӨӨР АЖИЛ, АЛБАН ТУШААЛ ХАВСРАХЫГ ХОРИГЛОХ



\$29.1

УИХ-ын гишүүн Үндсэн хуульд өөрөөр заагаагүй бол албан үүрэгт нь үл хамаарах өөр ажил, албан тушаал хавсран хийж болохгүй.

2000 оны нэмэлт, өөрчлөлт



- Давхар дээлийг тайлж УИХ гишүүн сайд болохыг хязгаарлана.
- Гишүүдийн хариуцлагыг нэмэгдүүлнэ.
- Ашиг сонирхлын зөрчил үүсэхээс сэргийлнэ.
- УИХ-ын гишүүний хавсарч үл болох ажил, албан тушаалд хязгаар тогтоож төрийн эрх мэдэл хуваарилах зарчмыг хэрэгжүүлэх боломжтой болно.
- УИХ-ын хуралдааны ирцэд тодорхой хэмжээгээр нөлөөлнө.
- Хуулийн чанар сайжирна.
- Төрийн эрх мэдлийн хуваарилалтын тэнцвэрийг хангана.

Парламентын гишүүний
үндсэн чиг үүрэг:



Төлөөлөх



Хууль тогтоох



Хянан шалгах



4. УЛСЫН ИХ ХУРАЛ ТАРАХ



§22.2



УИХ-ын нийт гишүүний 2/3-оос доошгүй нь “бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй” гэж үзвэл

УИХ өөрөө тарна

§22.3



Анхдугаар чуулганы хуралдаан эхэлснээс 45 хоногийн дотор Ерөнхий сайдыг томилоогүй бол

Ерөнхийлөгч УИХ-ыг тараана



Ерөнхий сайдыг шинээр томилох нөхцөл үүссэн өдрөөс хойш 30 хоногийн дотор томилоогүй бол

Ээлжит бус сонгууль

§22.4

Сонгуулийн тов зарлана



Ээлжит бус сонгууль явуулна



- УИХ хариуцлага хүлээдэг болно.
- Засгийн газрын тогтвортой, тасралтгүй ажиллагааг хангах боломж бүрдэнэ.
- Төрийн эрх мэдлийн хуваарилалтыг тэнцвэржүүлнэ.



5. УИХ-ЫН ЗАРИМ БҮРЭН ЭРХИЙГ ХЯЗГААРЛАХ



§ 25.1.6

Сайд нарыг томилох бүрэн эрхээсээ татгалзах

Ерөнхий Сайдад танхимаа өөрөө бүрдүүлэх боломжийг олгоно.

УИХ-ын гишүүд төсөвт дураар халдахыг хориглох

§ 25.1.7

Улсын төсвийг хэлэлцэн батлахдаа Засгийн газрын зөвшөөрөлгүй зардлын шинэ төрөл үүсгэж, зарлага нэмэгдүүлэхгүй.



-Засгийн газарт бие даан танхимаар ажиллах, хариуцлага хүлээх боломжийг бүрдүүлнэ.



- Иргэдийн татвараар бүрдсэн төсөвт тавих хяналт сайжирна.
- Мэргэжилтнүүдийн хийсэн тооцоог мэргэжлийн бус хүмүүс улс төрийн зорилгоор нэмэгдүүлэхгүй.
- УИХ гишүүд улсын төсөв боловсруулах явцад хяналт тавьж батална.
- Засгийн газар улсын төсвийг илүү хариуцлагатай боловсруулна.
- Нийтийн өмчийг шамшигдуулах явдлыг багасгана.
- УИХ-ын гишүүдийн өөртөө зориулан “гойргийн мөнгө” хуваарилахыг хязгаарлана.



6. ТӨРИЙН ХЯНАЛТЫГ САЙЖРУУЛАХ, ХЯНАН ШАЛГАХ ТҮР ХОРОО БАЙГУУЛАХ



§28.2

§28.3

§28.4



Түр хороо
байгуулах
санаачилга

УИХ-ын нийт
гишүүний 1/4 буюу
19-өөс доошгүй

Нийтийн ашиг
сонирхлыг хөндсөн
тодорхой асуудал



Бүрэлдэхүүн

Цөөнхийн
төлөөллийг
оролцуулна.



Эрх хэмжээ

- Шинжээч томилох
- Гэрч дуудах
- Тайлбар, мэдүүлэг авах
- Нотлох баримт гаргуулах



Дүгнэлт

- Шүүхэд үүрэг
хүлээлгэхгүй
- Баримтыг
нотлох
баримтад тооцох
эсэхийг шүүх
шийдвэрлэнэ.

“ Хянан шалгалтын түр хороо нь парламентын хяналтын хамгийн үр нөлөөтэй арга хэрэгсэлд тооцогддог. ”



- Гүйцэтгэх эрх мэдэлд тавих парламентын хяналт сайжирна.
- Цөөнхийн хяналт сайжирна.
- Мэдээлэл ил тод авах боломж нэмэгдэнэ.
- Парламент хяналтын үүргээ хэрэгжүүлнэ.
- Хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавина.



7. УИХ-ЫН СОНГУУЛЬТАЙ ХОЛБООТОЙ ЗААЛТ



§21.4



Ээлжит сонгуулиас 1 жилийн өмнө сонгуулийн хуульд өөрчлөлт оруулахгүй



ТОГТОЛЦОО

ХУУЛИАР
ТОГТООНО

ЖУРАМ



УИХ-ЫН СОНГУУЛИУД (1992-2016)



8. НАМЫН ЧИГ ҮҮРЭГ, САНХҮҮЖИЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРЧИМ



§19^{1.1}

Нам улсын хэмжээнд
үйл ажиллагаа явуулна

Иргэдийн улс төрийн
хүсэл зоригийг
илэрхийлнэ

§19^{1.2}

Намын зохион байгуулалт
ардчилсан зарчимд
нийцсэн байна.



Хөрөнгө, орлогын эх
сурвалж болон зарцуулалт
ил тод байна



- Улс төрийн намын дотоод ардчилал, үйл ажиллагааны болон санхүүгийн ил тод байдлыг сайжруулснаар хариуцлага нэмэгдэнэ.
- Улс төрийн намын чиг үүрэг, зохион байгуулалтын зарчмыг Үндсэн хуульд тусгах нь ардчилсан дэглэм төлөвшсөн улсуудад нийтлэг жишиг юм.
- Орон нутгийн шинжтэй нам байгуулахыг зөвшөөрөхгүй.






**ЗАСГИЙН ГАЗРЫН
ХАРИУЦЛАГЫГ
НЭМЭГДҮҮЛЭХ,
ТОГТВОРТОЙ
БАЙДЛЫГ ХАНГАХ**

1. ЗАСГИЙН ГАЗРЫГ ЭМХЛЭН БАЙГУУЛАХ



§39.1

Ерөнхий сайд



Засгийн газрын 4
гишүүн

УИХ-ЫН ГИШҮҮН БАЙЖ БОЛНО

2000 оны нэмэлт, өөрчлөлт



- Давхар дээлийг тайлна.
- Засаглалын тэнцвэртэй байдлыг хангана.
- Парламентын хяналт сайжирна.
- Ерөнхий сайд биечлэн хариуцлага хүлээдэг болно.

§39.2



УИХ-д олонхи суудал
авсан нам, эвсэл



УИХ-д суудал
авсан нам, эвсэл
зөвшилцөн
олонхийг бүрдүүлж

Ерөнхий
сайдад нэр
дэвшүүлсэн хүнийг
Ерөнхийлөгч 5
хоногийн дотор
УИХ-д оруулна.



аль ч нам, эвсэл
олонхийн суудал
аваагүй бол хамгийн
олон суудал авсан
нам, эвсэл бусад нам,
эвсэлтэй зөвшилцөн
олонхийг бүрдүүлж

2000 оны нэмэлт, өөрчлөлт



§39.3



2000 оны нэмэлт, өөрчлөлт

§39.4




- Ерөнхий сайд бодлого хөтөлбөрөө тууштай хэрэгжүүлэх нөхцөл бүрдэнэ.
- Эрх мэдлийн хяналт тэнцлийг сайжруулна.
- Гүйцэтгэх эрх мэдлийн үйл ажиллагаа нэгдсэн удирдлагад шилжинэ.

2. ЕРӨНХИЙ САЙДЫГ ОГЦРУУЛАХ ЖУРАМ



- Засгийн газрын тогтвортой ажиллах нөхцлийг хангана.
- Төрийн бодлого тогтвортой хэрэгжинэ.
- Үүрэг гүйцэтгэгч Ерөнхий сайд гэж байхгүй болно.
- Засгийн газрын үйл ажиллагаа тасалдахгүй болно.


УИХ ЕРӨНХИЙ САЙДЫГ ОГЦРУУЛСАН ТОХИОЛДЛУУД



1992 оноос хойш 14 Засгийн газар байгуулагдаж Засгийн газрын дундаж нас 1,8 жил байна.



3. ЕРӨНХИЙ САЙД ӨӨРТ НЬ ИТГЭЛ ҮЗҮҮЛЭХИЙГ ХҮСЭХ



- Засгийн газрын тогтвортой байдлыг хангана.
- Эрх мэдлийн хяналт-стэнцлийг сайжруулна.

4. ТӨРИЙН АЛБАНЫ ЗАРЧИМ

§46.4



ТӨРИЙН АЛБАНЫ ЗАРЧИМ



Улс төрийн шалтгаанаар ялгаварлан гадуурхахыг хориглоно	Сонгуулийн үр дүнгээр халах, чөлөөлөхийг хориглоно	Хуульд зааснаас бусад үндэслэлээр чөлөөлөх, халахыг хориглоно

Төрийн албаны чадахуйн зарчмын хэрэгжилтэд тавих хяналт хараат бус байна.

5. ЕРӨНХИЙЛӨГЧИД НЭР ДЭВШИХ ШАЛГУУРЫГ ӨНДӨРСГӨХ, БҮРЭН ЭРХИЙН ХУГАЦААГ НЭМЭХ

§30.2



ЕРӨНХИЙЛӨГЧИД НЭР ДЭВШИХ ШАЛГУУР




55 НАС ХҮРСЭН
МОНГОЛ УЛСЫН
ИРГЭН




СҮҮЛИЙН
ТАВААС
ДООШГУЙ ЖИЛ
ЭХ ОРОНDOO
БАЙНГА
ОРШИН
СУУСАН

ЕРӨНХИЙЛӨГЧИЙН БҮРЭН ЭРХИЙН ХУГАЦААГ НЭМЭГДҮҮЛЭХ



ЗУРГААН
ЖИЛИЙН
ХУГАЦААГААР
НЭГ УДАА
СОНГОНО



ЗӨВХӨН ЭНЭ
ЗҮЙЛД ЗААСАН
ХҮРЭЭНД
ХУУЛИАР
ОЛГОЖ БОЛНО



**ШҮҮХ ЭРХ
МЭДЛИЙН
ХАРИУЦЛАГЫГ
ДЭЭШЛҮҮЛЖ
ХАРААТ БУС
БАЙДЛЫГ ХАНГАХ**

1. ШҮҮГЧИЙН ТОМИЛГОО



§51.1

Улсын дээд шүүх Ерөнхий шүүгч, 21 шүүгчээс бүрдэнэ



Ерөнхий
шүүгч

+



21 шүүгч

=



Улсын дээд
шүүх

§51.2


Шүүхийн ерөнхий зөвлөл
шүүгчийг томилох шийдвэрээ
Ерөнхийлөгчид хүргүүлнэ.

Ерөнхийлөгч 21 хоногийн дотор батламжилна.
Үндсэн хуульд заасан шаардлага хангаагүй бол татгалзаж,
нийтэд мэдээлнэ.



**УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ШҮҮГЧИЙГ
ТОМИЛГООНЫ СОНСГОЛД ОРУУЛНА.**

**УИХ-д танилцуулж,
Ерөнхийлөгчид хүргүүлнэ.**

- 
- Шүүх эрх мэдлийн бие даасан байдал, хариуцлагыг дээшлүүлнэ.
 - Шүүгчийн томилгоог ил тод, тодорхой болгоно.
 - Шүүгчийн хараат бус байдлыг баталгаажуулна.
 - Олонхи болон цөөнхөд хүлээн эзөвшөөрөгдсөн хүмүүсийг сонгоно.



2. ШҮҮГЧИЙН МЭРГЭШСЭН, ХАРИУЦЛАГАТАЙ БАЙДЛЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ

§51.3

ШҮҮГЧИД ТАВИХ ШАЛГУУР



Анхан шатны
шүүх

- Хууль зүйн дээд боловсролтой
- Хуульчийн мэргэжлээр 5-аас доошгүй жил ажилласан
- Гучин нас хүрсэн Монгол улсын иргэн

Давж заалдах
шатны шүүх

- Тухайн шүүн таслах ажлын төрлөөр 6-аас доошгүй жил дагнан ажилласан

Улсын дээд
шүүх

- Хууль зүйн дээд боловсролтой
- Хуульчийн мэргэжлээр 15-аас доошгүй жил ажилласан
- Дөчин нас хүрсэн Монгол улсын иргэн
- 12 жилийн хугацаагаар зөвхөн нэг удаа томилно.

§51.5

ЕРӨНХИЙ ШҮҮГЧИЙГ ТОМИЛОХ

Тухайн
шүүхийн
шүүгчдийн
олонхи



СОНГОНО



3 жил



Бүх шатны
шүүхийн
Ерөнхий
шүүгч



- Шүүгчид тавигдах болзол, шаардлагыг өндөрсгөнө.
- Шүүгчийн мэргэшил, хариуцлагатай байдлыг дээшлүүлнэ.
- Шүүх эрх мэдлийн бие даасан, хариуцлагатай байдлыг нэмэгдүүлнэ.



3. ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮНИЙГ ТОМИЛОХ

§49.5



ТОМИЛГОО

УИХ-ын холбогдох
Байнгын хороо

5 | 5
Гишүүн

Хяналтын шат 1
Давж заалдах шат 1
Анхан шат 3

- Нэр дэвшүүлнэ.
- Томилгооны сонсгол хийнэ.
- Хуралдаанд оролцсон гишүүдийн 2/3 доошгүй саналаар томилно.

ШАЛГУУР

- Хууль зүйн өндөр мэргэшилтэй
- Мэргэжлээрээ 10-аас доошгүй жил ажилласан
- Монгол улсын иргэн

Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн 4 жилийн хугацаагаар нэг удаа ажиллана.



- Шүүх эрх мэдлийн бие даасан байдал, хариуцлагыг дээшлүүлнэ.
- Шүүгчийн томилгоог ил тод, тодорхой болгоно.
- Шүүгчийн хараат бус байдлыг баталгаажуулна.
- Шүүхийн ерөнхий зөвлөл дэх улс төрийн нөлөөллийг сааруулна.



4. ШҮҮГЧИЙН ХАРИУЦЛАГЫН ЗӨВЛӨЛ БАЙГУУЛАХ

\$49.6



\$49.7

\$49.8



ШҮҮГЧИЙН
ХАРИУЦЛАГЫН
ЗӨВЛӨЛ

9 гишүүнтэй



БҮРЭН ЭРХ

хуульд заасан үндэслэл, журмын дагуу шүүгчийг
албан тушаалаас нь түдгэлзүүлэх,
огцруулах,
бусад шийтгэл ногдуулах,
чөлөөлөх шийдвэр гаргана.

Гишүүд
дотроосоо



Зөвлөлийн
даргыг сонгоно



НЭГ УДАА СОНГОНО



Шүүгчид хариуцлага хүлээлгэх тогтолцоог шударга, үр
нөлөөтэй болно.

5. ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ГИШҮҮНД ТАВИГДАХ ШААРДЛАГА

§65.1

§65.2



Томилгооны
сонгол хийж УИХ
нийт гишүүний
олонхийн саналаар
томилно.



Нэг удаа
ТОМИЛНО.

Үндсэн хуулийн
цэц 9 гишүүнээс
бүрдэнэ.


40 нас хүрсэн
Монгол Улсын
иргэн байна.



Хууль зүйн өндөр
мэргэшилтэй ,
мэргэжлээрээ 15-
аас доошгүй жил
ажилласан



- Үндсэн хуулийн цэцийн гишүүний хариуцлага, хараат бус байдлыг дээшлүүлнэ.
- Үндсэн хуулийн шүүх сонгодог утгаараа хөгжинө.
- Улс төрийн нөлөө багасна.




**НУТГИЙН
УДИРДЛАГЫН
ТОГТОЛЦООГ
БОЛОВСРОНГУЙ
БОЛГОХ**



1. ХОТЫН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫГ ТОДОРХОЙ БОЛГОХ:



МОНГОЛ УЛСЫН НУТАГ ДЭВСГЭР НЬ ЗАСАГ ЗАХИРГААНЫ ХУВЬД:



Улсын болон орон нутгийн харьяалалтай хот, тосгоны эрх зүйн үндэс, тэдгээрийн өөрийн удирдлагын болон засаг захиргааны зохион байгуулалтын зарчмыг хуулиар тогтооно.




- Хотын статусыг тодорхой болгоно.
- Хот суурин газрын хөгжлийг дэмжинэ.



2. НУТГИЙН ӨӨРӨӨ УДИРДАХ БАЙГУУЛЛАГЫН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫГ ТОДОРХОЙЛОХ

§59.2 §59.3 §60.2 §60.3



§59.4



Баг, хорооны иргэдийн нийтийн хурал

- Хуулиар заасан хүрээнд
- Сум, дүүргийн ИТХ-аас олгосон эрх хэмжээний хүрээнд тухайн нутаг дэвсгэрт хамаарах асуудлаар шийдвэр гаргана



МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТИЙГ ДАГАЖ МӨРДӨХӨД ШИЛЖИХ ЖУРМЫН ТУХАЙ ХУУЛЬ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэн холбогдох хуулийг шинэчлэн батлах хүртэл хугацаанд тухайн харилцааг зохицуулж ирсэн хуулийг баримтална. Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх ажлыг Улсын Их Хурлаас баталсан хуваарийн дагуу хийж дуусгана.

2 дугаар зүйл. Монгол Улсын Үндсэн хуулийн Гучдугаар зүйлийн 2 дахь хэсэгт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг 2025 онд болох Ерөнхийлөгчийн ээлжит сонгуулиас эхлэн дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт оруулсан нэмэлт, өөрчлөлт нь 2020 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө томилогдсон анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгчид хамаарахгүй.

4 дүгээр зүйл. 2020 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө томилогдсон Улсын дээд шүүхийн шүүгчийн бүрэн эрхийн хугацаа нь Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн 12 жил байна.

5 дугаар зүйл. 2020 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө томилогдсон Үндсэн хуулийн цэцийн гишүүний бүрэн эрхийн хугацаа 6 жил байна.

6 дугаар зүйл. Энэ хууль нь Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн нэгэн адил хүчинтэй.

7 дугаар зүйл. Энэ хуулийг 2019 оны ... сарын ...-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

---o0o---

ХАРИУЦЛАГАТАЙ

ТОГТВОРТОЙ

ТЭНЦВЭРТЭЙ